



Хэвлэлийн мэдээ

Монгол улс: Уул уурхай хүний эрхийн хамгаалагчид, орон нутгийн иргэд болон байгаль орчинд аюул учруулж байгааг Хүний эрхийн байгууллагын тайлан дэлгэж байна

(Улаанбаатар/Бангкок, 2019 оны 10-р сарын 22 өдөр) – Үйл ажиллагааны чиглэл, цар хүрээнээс үл хамааран Монгол улсын зүүн хойд бүс нутгийн Биндэр, Батноров, Цагаан-Овоо сумдын байгаль орчин, орон нутгийн иргэдэд уул уурхай ноцтой аюул учруулж байна.

Хүний Эрх болон Хөгжлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Азийн Форум (ФОРУМ-АЗИ) болон Монгол улсын Хүний Эрх Хөгжил Төв (ХЭХТ)-өөс 2019 оны 5-р сард хийсэн баримтжуулах томилолтын “Бидний газар нутаг” тайланг өнөөдөр танилцууллаа. Энэхүү тайланд Дорнод аймгийн нутагт үйл ажиллагаа явуулж буй уурхайн нөлөөний талаарх оролцогч талуудын түүхийг оруулжээ.

Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль (урт нэртэй хууль)-ийг хэрэгжүүлэх журам зэрэг хуулийн цоорхой нь уул уурхайн компаниудад Монгол улсын биологийн олон янз байдлыг хадгалан хамгаалах гэсэн зорилготой зүйл заалтуудыг үл хэрэгсэх боломжийг олгож байгаа юм. Үүнээс улбаалан орон нутгийн ард иргэдийн аюулгүй байдал, амьжиргаанд эрсдэл учруулаа нь нэмэгдэж байна. Үүний зэрэгцээ бичил уурхайн олборлолт нөхцөл байдлыг улам хурцатгаж, нутгийн ард иргэдэд дарамт үзүүлэх төдийгүй малын бэлчээрт ихээхэн хор хохирол учруулж байна.

Томоохон хэмжээний уул уурхайн үйл ажиллагааг эсэргүүцэн тэмцэж буй орон нутаг дахь хүний эрхийн хамгаалагчид, эмэгтэй хүний эрхийн хамгаалагчдад хамгийн их тулгарч буй хүчирхийллийн хэлбэрүүд нь айлган сүрдүүлэг, заналхийлэл байгааг тайланд ил болгосон. Орон нутаг дахь хүний эрхийн хамгаалагчдын өгсөн мэдээлэл нь Монголын хүний эрхийн хамгаалагчид ихээхэн аюул эрсдэлтэй тулгараад байгааг харуулж байгаа юм.

Дээр дурьдсан баримтууд дээр тулгуурлан Монгол улсын хууль журам, олон улсын хүний эрхийн стандартаар хүлээсэн Монгол улсын үүргийн үүднээс Монгол улсын Засгийн Газраас Хүний эрхийн хамгаалагчийн тухай хуулийн төслийг чангатгаж бизнесийн үйл ажиллагаатай холбоотой хүний эрхийн зөрчлийг өмгөөлөн ажиллаж байгаа эрх хамгаалагчдыг хамгаалах, Бизнес болон Хүний эрхийн Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхийг шаардаж байна. Монгол улсын Хүний Эрхийн Үндэсний Коммист орон нутаг дахь ажилтнуудын эрх мэдэл, нөөц бололцоог нэмэгдүүлэн үйл ажиллагаагаа өргөтгөх зөвлөмжийг энэхүү тайланд оруулсан болно. Мөн Хэнтий аймгийн Засаг даргын тамгын газар, Батширээт, Биндэр болон Цагаан-Овоо сумдын Засаг даргын тамгын газар, уул уурхайн Айвуунтэс, Пегматит, Стэп Гоулд компаниуд, Монгол улсад энэ оны 5 болон 9-р саруудад албан айлчлал хийсэн Хүний эрхийн хамгаалагчдын асуудлаарх НҮБ-ын тусгай илтгэгч нарт зөвлөмж өгсөн.

Тайлангийн бүрэн эхийг дараахь холбоосоор үзнэ үү [англи хэлээр]: <https://www.forum-asia.org/uploads/wp/2019/10/FFM-Mongolia-2019-Report.pdf>

Тайлангийн хураангуй [англи/монгол хэлээр]: <https://www.forum-asia.org/uploads/wp/2019/10/Summary-FFM-Mongolia-Report-2019.pdf>

Нэмэлт мэдээлэл авах бол дараахь хаягаар холбоо барина уу:

hrd@forum-asia.org

dkm@forum-asia.org

chrd@mongolnet.mn